



МОНГОЛ УЛС

**МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН
ЗОРИЛТУУДЫН
ХЭРЭГЖИЛТ**

**ҮНДЭСНИЙ ХОЁР ДАХЬ ИЛТГЭЛ
ХУРААНГУЙ**

Улаанбаатар
2007

Агуулга

<i>Ерөнхий байдал</i>		3
<i>Монгол Улс МХЗ-уудыг сайшаан дэмжсэн нь</i>		3
<i>Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги</i>		3
<i>Монгол Улсын МХЗ-уудын онцлог</i>		4
<i>МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлийн зорилго</i>		4
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ		5
<i>Зорилго 1</i>	<i>Ядуурал, өлсгөлөнг бууруулах</i>	5
<i>Зорилго 2</i>	<i>Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших</i>	7
<i>Зорилго 3</i>	<i>Хүйсийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх</i>	8
<i>Зорилго 4</i>	<i>Хүүхдийн эндэгдлийг бууруулах</i>	10
<i>Зорилго 5</i>	<i>Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах</i>	10
<i>Зорилго 6</i>	<i>Бэлгийн замын халдварт өвчин, Хүний дархлал хомсдлын вирус /ХДХВ/, Дархлалын олдмол хомсдол /ДОХ/, Сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах</i>	12
<i>Зорилго 7</i>	<i>Байгаль орчны тогтвортой байдлыг хангах</i>	14
<i>Зорилго 8</i>	<i>Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх</i>	16
<i>Зорилго 9</i>	<i>Хүний эрхийг баталгаажуулах, Ардчилсан засаглалыг хөгжүүлэх</i>	17
<i>МХЗ-уудын орон нутаг дахь хэрэгжилт</i>		19
<i>МХЗ-уудын хяналт-шинжилгээ, үнэлгээ</i>		21
<i>МХЗ-уудыг хангахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээний үнэлгээ</i>		22
<i>Санхүүжилтийн стратеги</i>		22
<i>Сургамж</i>		23
<i>Хавсралт 1</i>	<i>МХЗ-уудын хэрэгжилтийн хандлагын шинжилгээ, үнэлгээ</i>	26
<i>Хавсралт 2</i>	<i>МХЗ-уудыг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний матрицын үнэлгээ, 2006</i>	28
<i>Хавсралт 3</i>	<i>МХЗ-уудын зарим гол шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон үнэлэмж, 2006 (аймгуудыг байр эзлүүлснээр)</i>	30

Ерөнхий байдал

1. Монгол Улс нь ОХУ болон БНХАУ-ын хооронд Төв Азийн эх газрын төвд оршдог, 1.5 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай, нутаг дэвсгэрийн хэмжээгээр дэлхийд 17 дугаарт ордог, 2006 оны байдлаар 2.6 сая хүн амтай. Засаг захиргааны 21 аймаг, нийслэлд хуваагддаг. Нийт хүн амын 60.9 хувь нь хот, суурин газарт, 40 орчим хувь нь хөдөө, орон нутагт, нийслэл Улаанбаатар хот улсын нийт газар нутгийн 0.3 хувийг эзэлдэг ч нэг сая орчим хүн оршин суудаг.
2. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс (ХХИ) 2006 оны байдлаар 0.691¹ байгаа нь хүний хөгжлөөрөө дунд зэргийн гэсэн ангилалд хамрагдаж байна. Нэг хүнд ногдох ДНБ оны үнээр 1,440.7 мянган төгрөг (1221.4 ам.доллар)-т хүрчээ. 2006 онд нийт хүн амын 32.2 хувь нь ядуу байна.

Монгол Улс МХЗ-уудыг сайшаан дэмжсэн нь

3. Мянганы Тунхаглалыг дэмжин хүлээн авсан бусад орнуудын нэгэн адил Монгол Улс өөрийн орны өвөрмөц онцлогт нийцүүлэн тулгамдсан асуудлуудыг тодорхойлон холбогдох зорилго, зорилтуудаа томъёолж, шаардлагатай бодлого, арга хэмжээ, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын Мянганы хөгжлийн 2015 он хүртэлх зорилтуудаа тодорхойлсон.

Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги

4. Монгол Улс нь сүүлийн 17 жилд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай төрийн захиргааны тогтолцоог бүхэлд нь өөрчлөн шинэчилж, зах зээлийн эдийн засаг, нийгмийн бүтцийг бий болгон шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлүүдийг даван туулах, ардчилсан нийгмийн үндэс суурийг тавих асуудалд гол анхаарлаа хандуулж ирлээ.
5. Өнөөгийн байдлаар хөгжлийн гол баримт бичгүүд гэвэл Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2004-2008), Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтууд (1990-2015), Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл түүнчлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлагаар Ерөнхий сайдаар ахлуулсан ажлын хэсэг 2006 оноос эхлэн боловсруулсан Монгол Улсын хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлсон “Монгол Улсын МХЗ-уудад тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого” баримт бичгийн төсөл зэргийг нэрлэж болно. Үндэсний хөгжлийн цогц бодлого нь 2021 он хүртэлх хугацааг хамарч байгаа юм.
6. Монгол Улсын Мянганы хөгжлийн 2015 он хүртэлх хугацааны зорилтуудыг УИХ-аас 2005 онд тодорхойлон батлахдаа улс орны хөгжлийн бодлого, стратегийн баримт бичгүүдтэй уялдууж, эдийн засгийн өсөлтийн дүнд бий болсон баялгийг иргэдэд зохистой

1 НҮБ, Хүний хөгжлийн илтгэл, 2006

хуваарилах, ядуучууд, ядуурлын ирмэгт ойрхон байгаа хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, тэдгээрийн идэвхи санаачлагыг дэмжих замаар амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн бодлого, арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын МХЗ-уудын онцлог

7. Монгол Улс нь үндэснийхээ МХЗ-уудыг тодорхойлохдоо хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх асуудлыг МХЗ-уудынхаа салшгүй хэсэг болгон шинээр оруулж нийт 9 зорилго, 22 зорилт, 24 үзүүлэлтийг дэвшүүлсэн.
8. Монгол Улсын үндэсний МХЗ-ууд нь Мянганы Тунхаглалд тодорхойлогдсон зорилго, зорилтуудтай агуулгын хувьд үндсэндээ ижил төстэй боловч тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд, зарим нэгэн аргачлалын ялгаатай талууд бий. Тухайлбал, ядуурлын хамралтын хүрээг өдөрт нэг ам.доллараас хэтрэхгүй орлоготой буюу хэрэглээтэй хүн амын хувийн жингээр² бус, харин амьжиргааны доод түвшнээс доогуур амьдралтай хүмүүсийн хувийн жингээр тогтоож байна.
9. Орон нутаг дахь МХЗ-уудын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн түвшинд тодорхойлон, үйл ажиллагаа, санхүүжилтийг уялдуулах туршилтын ажлыг 4 аймаг, 2 дүүрэгт эхлүүлээд байна.

МХЗ-уудын хэрэгжилтийн Үндэсний хоёр дахь илтгэлийн зорилго

10. Үндэсний илтгэлийн зорилго нь МХЗ-уудын 2005-2006 оны хэрэгжилтийн явцыг хянаж үнэлэх, хэрэгжилтийн талаарх албан ёсны мэдээлэл, статистик тоо баримтуудыг олон нийтийн хүртээл болгох, зорилтуудын хэрэгжилтийг хангахад шаардлагатай асуудлуудад холбогдогч талуудын анхаарлыг хандуулах, тэдгээрийг бодлого, арга хэмжээнд тусган хэрэгжүүлэхэд оршино.
11. Үндэсний илтгэлийг холбогдох салбарын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, шалгуур үзүүлэлтүүдийн статистикийн албан ёсны мэдээлэлд үндэслэн боловсруулсан бөгөөд иргэний нийгмийн оролцоог хангах, олон улсын болон төрийн бус байгууллага (ТББ)-уудын гүйцэтгэсэн судалгааны үнэлгээ, дүгнэлтийг тусгах зорилгоор ажлын хэсэг, үндэсний зөвлөх, судлаачдын багийг ажиллуулсан болно.

2 НҮБ, МХЗ-ын хяналт шинжилгээний үзүүлэлтүүд: Тодорхойлолт, харьцаа, үзэл баримтлал, эх сурвалж. Нью-Йорк, 2003

МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУДЫН ХЭРЭГЖИЛТ

ЗОРИЛГО 1 Ядуурал, өлсгөлөнг бууруулах

Зорилт 1: *Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах*

Ядуурлын шугамаас доогуур амьдарч буй хүн амын эзлэх хувь

12. Монгол Улсын нийт хүн амд амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь 1990 онд 36.3, 2000 онд 35.6, 2005 онд 36.1 байсан бол 2006 онд 32.2 хувь болж буурчээ. Ядуурлын гүнзгийрэлт 2002-2003 онд 11.0, 2006 онд 10.1 хувь болсон нь ядуучуудын хэрэглээний дундаж түвшин ядуурлын шугамны дунджаас 10 хувиар доогуур байгааг харуулж байна. Ядуурлын түвшин хот, суурин газартай харьцуулахад хөдөөд илүү байна. Хотын ядуурлын хэмжээ 2003-2006 онд 30.3 хувиас 27.0 хувь, хөдөөгийн ядуурал 43.4 хувиас 37 хувь хүртэл буурчээ.
13. Ядуурлын шугамаас доогуур орлоготой хүн амын эзлэх хувийг 2015 он гэхэд 2 дахин бууруулахаар дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийн байдлаас үзэхэд Засгийн газраас олон бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа боловч ядуурлын түвшин маш бага хувиар буурчээ. Хэрэв энэ байдлаар цааш үргэлжилвэл 2015 он хүртэл дэвшүүлсэн зорилтоо хангах боломжгүй бөгөөд үүний тулд ядуурлыг эрчимтэй бууруулах тусгай стратегийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зорилт 2: *Хоол, тэжээлийн дуталтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах*

Тав хүртэлх насны хүүхдийн хоол, тэжээлийн дутлын байдал

14. Хоол, тэжээлийн дутлын өнөөгийн байдлыг тав хүртэлх насны хүүхдийн хоол, тэжээлийн дутлаар тодорхойлж байна. Тав хүртэлх насны хүүхдийн тураал 2000 онд 12.7 хувь байсан бол 2006 онд 6.3 хувь болж буурчээ. Энэ байдлаар цаашид буурвал 2015 он хүртэл дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангах бололцоотой байна. Хөдөө, орон нутгийн хүүхдүүд хот, суурингийнхнаас 2 дахин их тураал болон өсөлтийн

хоцролтод өртөж байна. Баруун бүсийн бага насны хүүхдийн тураалын түвшин нь Хангайн болон Улаанбаатараас их байна.

15. Хүүхдийн хоол, тэжээлд аминдэм, бичил бодисын хангамж чухал нөлөөтэй. Тав хүртэлх насны хүүхдүүдийн 41 хувь нь Д аминдэмийн дуталтай, 20.8 хувь нь зулай зөөлөн, хөл нь майга, үе мөч нь хавдартай, 21.4 хувь нь цус багадалттай байна. 6-59 сартай хүүхдийн 51.6 хувь нь А аминдэмийн түгээлтэд хамрагдаж байна. 6-12 насны хүүхдийн дунд бамбайн бахлуурын тархалт 13.8 хувь байна.

Хүн амын хоол хүнснээс авах хэрэгцээт илчлээ

16. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (ХХААБ)-ын үнэлгээний 2006 оны тайланд³ 1999-2001 онд Монгол Улсын хүн амын 38 хувь нь өлөн зэлмүүн байдалд байсан бол 2002-2004 онд 27 хувь болж буурсан гэж дүгнэжээ. НҮБ-ын ХХААБ-ын тусгай илтгэгч илтгэлдээ ядуу өрхийн гишүүний хоногийн хоолны илчлэгийн хэмжээ дөнгөж 1,784 ккал байгаа нь олон улсын (2,100 ккал) болон Монгол улсын (2,731 ккал) стандартаар тогтоосон хэмжээнд ч хүрэхгүй байна гэсэн дүгнэлт хийжээ.

Зорилт 3: *Залуучуудад зориулсан таатай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх, газар ашиглах боломжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх журмыг хөнгөвчлөх, ажил эрхлээгүй иргэн бичил зээл авах боломжийг бий болгох замаар ажилгүй хүмүүс ялангуяа залуучуудад зориулсан ажлын байрыг бий болгох*

Залуучуудын хөдөлмөр эрхлэлт

17. 2006 онд 15-24 насны залуучууд нийт хүн амын 21.9 хувийг эзэлж байв. Нийт ажиллагчдын дунд 25 хүртэлх залуучуудын эзлэх хувь буурах хандлагатай байна. 2000-2005 оны хооронд 28.4-өөс 23 хувь болж буурчээ. 15-24 насны хүмүүсийн ажилгүйдлийн түвшин 2004 онд 3.6 хувь байсан бол 2005 онд 3.3 хувь болжээ. Бүс нутгаар авч үзвэл Хангай, Баруун, Зүүн бүсэд ажилгүйдлийн түвшин өндөр байна.

Зорилт 4: *Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжигсдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх*

18. Сүүлийн жилүүдэд хүн амын дотоод шилжих хөдөлгөөн эрчимжсэн байна. Шилжин суурьших үйл явц эрчимжснээр хот, суурин газрын дэд бүтэц болон бусад үйлчилгээнд нэмэлт хүндрэл учруулсаар байна. Улаанбаатар хотын сургуулиуд 3 ээлжээр хичээллэх, нэг ангид 40-50 гаруй хүүхэд суралцахын зэрэгцээ “харьяаллын бус”, “хамран сургах тойргийн бус” хэмээх нэртэй хүүхдүүд шилжин ирсэн сургуульдаа ачаалал хэтэрсний улмаас суралцаж чадахгүй байх, завсардах бэрхшээлүүд гарч байна. Түүнчлэн хөдөөнөөс хотод шилжин ирэгсдийн ихэнх нь бичиг баримтын зөрчилтэй байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасган хүн амын хэт төвлөрсөн болон зохисгүй бөөгнөрлийг сааруулж нутаг орондоо суурьшин амьдрах сонирхлыг дэмжих бодлого явуулах шаардлагатай байна.

ЗОРИЛГО 2 БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭМШИХ

Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох

Бага боловсролын өнөөгийн байдал

19. Нэгдүгээр ангид элсэн ороод тавдугаар анги хүртэл суралцагчдын хувь 1990 онд 91.0 байсан бол 2000 онд 86.8 болон буурчээ. Энэ үзүүлэлт дорвитой нэмэгдэхгүй байгаагийн гол шалтгаан нь сургууль завсардсан хүүхдүүдийн дийлэнх нь бага боловсролын эхний ангиудаас завсардаж байгаатай холбоотой юм.

1 дүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь

20. Дотуур байрны хүрэлцээ хангамж муугаас хөдөөгийн малчдын хүүхэд дотуур байранд бүрэн хамрагдаж чадахгүй байна. 2006-2007 оны хичээлийн жилд дотуур байранд суух хүсэлт гаргасан ЕБС-ийн хүүхдийн тоо 51,167 байснаас 16 хувь нь дотуур байранд хамрагдаж чадаагүй байна. Бага боловсролын үйлчилгээ, хүртээмжийг сайжруулах багц арга хэмжээ авах замаар дээр дурьдсан хүндрэл бэрхшээлийг арилгах шаардлага тулгарч байна.

15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалт

21. Хүн ам, орон сууцны 1989 оны тооллогоор хүн амын 99 хувь нь бичиг үсэгт тайлагдсан байсан бол 2000 оны тооллогоор 97.7 хувь нь бичиг үсэгт тайлагдсан гэсэн дүн гарчээ. 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшнээр Улаанбаатар (99.5 хувь), хамгийн өндөр үзүүлэлттэй, харин Сүхбаатар (93.6 хувь) аймаг хамгийн доогуур үзүүлэлттэй гарсан байна. Хамгийн өндөр үзүүлэлттэй Улаанбаатар, хамгийн доогуур үзүүлэлттэй Сүхбаатар аймгийн 15-24 насны

залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшний зөрүү 5.9 пункт байна. Энэ нь 15-24 насны залуучуудын бичиг үсэг тайлагдалтын түвшний ялгаа аймгуудын хооронд харьцангуй бага байгааг харуулж байна. Бичиг үсэг үл мэдэгч 15-24 насны өсвөр залуучуудын 66.3 хувь нь эрэгтэйчүүд байна.

ЗОРИЛГО 3 ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ

Зорилт 6. *2005 онд бага болон дунд боловсрол зэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах*

Бага боловсрол эзэмшиж байгаа охид хөвгүүдийн харьцаа

22. 1990 онд бага боловсрол эзэмшиж байсан охидын тоо хөвгүүдээс илүү байлаа. Энэ үзүүлэлт 1.03 байсан бөгөөд 2000 онд 1.01 болж 2006 онд 0.98 болон буурчээ. Оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлснээр 2015 онд 1.0-д хүрэх боломжтой юм.

Дунд боловсрол эзэмшиж буй охид хөвгүүдийн харьцаа

23. Ерөнхий боловсролын сургууль завсардагчдын дийлэнх нь эрэгтэй хүүхэд байгаа бөгөөд ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа 1997 онд хамгийн өндөр буюу 1.33 байжээ. Энэ үзүүлэлт 2000 онд 1.20 байснаа 2005 онд 1.11 болж тасралтгүй буурч, 2006 онд 1.03 болжээ. Үүнээс үзэхэд 2015 онд дэвшүүлсэн энэ зорилтыг бүрэн хангах боломжтой байна.

Дээд боловсрол эзэмшиж буй охид, хөвгүүдийн харьцаа

24. Дээд боловсрол эзэмших түвшинд охид дийлэнх нь байна. Энэ харьцаа 2000 онд 1.72 байснаа жил тутам аажим буурсаар 2005, 2006 оны байдлаар 1.53 болоод байна. Дээд боловсрол эзэмшигчдийн хүйсийн харьцаа болон нөлөөлөх хүчин зүйлүүдийн нарийвчилсан судалгаа хийж дүгнэлт гаргах шаардлагатй байна.

ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлж байгаа эмэгтэйчүүдийн эзлэх хувь

25. Монгол Улсын нийт хүн амын 50.4 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. ХАА-гаас бусад салбарт цалинтай ажил эрхэлдэг эмэгтэйчүүдийн

эзлэх хувь 1990 онд 51.1 байсан бол 2000 онд 50.4 хувь, 2006 онд 53.9 хувь болжээ.

26. Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн ажиллаж буй салбар, эрхэлж буй ажил, мэргэжлээс хамаарч цалингийн ялгаа гарч байна. Эрэгтэйчүүдийн дундаж цалин эмэгтэйчүүдийнхээс өндөр байхад эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс илүү олон цагаар ажиллаж байна. Энэ нь боловсролын түвшнээс хамаарахгүй байгаа бөгөөд цалин, хөдөлмөрийн хөлсний улсын дунджаар эрэгтэйчүүдийн цалин эмэгтэйчүүдийнхээс 10.0 мянган төгрөгөөр илүү байна. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн зах зээл дээр гарч цалинтай ажил эрхлэхийн зэрэгцээ гэр бүлийнхээ сайн сайхны төлөө үр хүүхдээ харах, өвчтэй хүн, хөгшдийг асрах, хоол хүнсээ бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд илүү цаг зарж байгааг харуулж байна⁴.

Үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүд

27. Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх суудлын хувийн жин нь эмэгтэйчүүдийн улс төр, нийгмийн амьдрал дахь оролцооны нэг чухал илэрхийлэл юм. 2006 оны байдлаар парламентад сонгогдсон нийт гишүүдийн дотор эмэгтэйчүүд 6.6 хувь байгаа нь 2000 онд 11.8 хувь байсан амжилтаасаа ухарсан төдийгүй шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо дорвитой нэмэгдээгүй байна. Цаашид жендэрийн тэгш байдлыг хангах зорилттой уялдуулсан хууль эрх зүйн таатай орчин бий болгох, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавьдаг, үр дүнг тооцдог болох шаардлагатай байна.
28. Өнөөгийн байдлаар аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ)-д эмэгтэйчүүдийн эзлэх хувь 24.6-д хүрсэн нь орон нутагт эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх харьцангуй өндөр, нийгэмд танигдсан, нэр хүндтэй, чадавхитай эмэгтэйчүүд олон байгааг илэрхийлж байна.

Үндэсний парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүд

29. Үндэсний парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь 1992 онд 7.7 байсан бол 2004 онд 13.7 хувь болон өссөн хэдий ч энэ үзүүлэлт доогуур байгаа юм. Иймд үндэсний парламентад сонгогдох эмэгтэйчүүдийн тоог нэмэгдүүлэхийн тулд тодорхой алхмуудыг хэрэгжүүлэх шаардлагатай.

4 ҮСГ, Ажиллах хүчний судалгааны тайлан, 2004

ЗОРИЛГО 4 ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 7. *Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёроор бууруулах*

Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин

30. Монгол Улсад нялхсын болон тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 1990 оноос хойшхи 16 жилийн хугацаанд эрчимтэй буурчээ. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 1990 онд 88.8 байснаа 2006 он гэхэд 3.7 дахин буурч, 23.2 болжээ. 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн энэ зорилтыг 2006 оны байдлаар бүрэн хангаад байгаа бөгөөд цаашид бууруулах боломж байна.

Нялхсын эндэгдлийн түвшин

31. 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 1990 онд 64.4 байснаа 2006 онд 19.1 буюу 3.3 дахин буурсан байна. 2015 онд хүрэх зорилтыг 2006 оны байдлаар бүрэн хангаад байна.

32. Нялхсын эндэгдэл буурч байгаа боловч нийт эндэгдлийн дотор нярайн эндэгдлийн эзлэх хувь нэмэгдэж байна⁵. Нярайн эндэгдэл жирэмсэн эхийн эрүүл мэнд, төрөх үеийн хүндрэлтэй ихээхэн холбоотой байдаг. Монгол Улсад хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч байгаа боловч ураг нярайн тусламж үйлчилгээнд оношлогоо эмчилгээ, урьдчилан сэргийлэх дэвшилтэт технологи нэвтрүүлж, эхийн эрүүл мэндийг сайжруулах, төрөх үеийн хүндрэлээс сэргийлэх шаардлагатай байна.

Улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхдийн хувь

33. Монгол Улсад дархлаажуулалтын өргөжүүлсэн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж байна. 2006 оны байдлаар улаан бурхны эсрэг вакцинжуулалтад хамрагдсан хүүхэд 98.9 хувьд хүрч дэвшүүлсэн зорилтыг бүрэн хангасан байна.

ЗОРИЛГО 5 ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ

Зорилт 8: *Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд дөрөвний гурваар бууруулах*

Эхийн эндэгдлийн түвшин

34. Монгол Улсад эхийн эндэгдэл сүүлийн 5 жилд тогтвортой буурч байна. Нөхөн үржихүйн эрүүл мэнд Үндэсний хоёр дахь хөтөлбөр 2002-2006 онд амжилттай хэрэгжсэнээр эхийн эндэгдэл 1990 онд 100,000 амьд төрөлтөд 121.6 байсан бол 2000 онд 166.3, 2006 онд 67.2 болж 1990 онтой зэрэгцүүлэхэд бараг 2 дахин буурсан байгаа нь 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтыг хангах боломжтой байна.
35. Гэсэн ч зарим аймгуудад эхийн эндэгдэл харьцангуй өндөр хэвээр байна. Говьсүмбэр аймагт 2005, 2006 онд эхийн эндэгдэл хамгийн өндөр байжээ. Эхийн эндэгдэл төвөөс алслагдсан Дорнод, Сүхбаатар, Баян-Өлгий, Говь-Алтай зэрэг аймагт илүү байна Харин сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотод нэмэгдэх хандлагатай байна.

Эрүүл мэндийн мэргэжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь

36. Эрүүл мэндийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь тогтвортой нэмэгдэж 2006 онд 99.7 хувь байна. Жирэмсэн эхчүүдийн 81.5 хувь нь жирэмсний эрт үедээ үзлэг хяналтад хамрагдаж, 82.2 хувь нь 6 ба түүнээс дээш удаа үзлэг хяналтад хамрагджээ⁶. Эрүүл мэндийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь тогтвортой нэмэгдэж 99.7 хувь байгаа нь 2015 онд хүрэхээр дэвшүүлсэн зорилтыг хангах боломжтой байна.
37. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн 46 хувь суурь өвчтэй⁷, жирэмсэн эмэгтэйчүүдийн 47.1 хувь нь төмөр, 37.1 хувь нь “Д” аминдэмийн дутагдалтай байна. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 70.7 хувь нь зөвхөн жирэмсний сүүлийн сард төмрийн бэлдмэлийг хэрэглэжээ⁸. Эхийн эндэгдлийн шалтгаанд жирэмсэн үеийн хүндрэл 33.3 хувь, төрөх үеийн хүндрэл 21.2 хувь, төрсний дараах үеийн хүндрэл 15.2 хувь, жирэмсэнтэй хавсарсан өвчин 30.3 хувийг эзэлж байна. Энэ нь жирэмсний хяналтын чанар муу, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал сул байгааг харуулж байна.

6 ЭМЯ, Эрүүл мэндийн үзүүлэлтүүд, 2006

7 ЭМЯ, ЭНЭШТ, Эхийн эндэгдлийн өнөөгийн байдал, 2001, 2002, 2003

8 Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, 2004

ЗОРИЛГО 6 БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДЛЫН ВИРУС /ХДХВ/, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ /ДОХ/, СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ

Зорилт 9: 2015 он гэхэд Хүний дархлалын халдварт вирус (ХДХВ), Дархлалын олдмол вирус (ДОХ) өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх

15-24 насны жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд ХДХВ өвчний тархалт

38. Монгол Улсын нийт хүн амын дунд Хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ), Дархлалын олдмол хомсдол (ДОХ)-ын тархалтын түвшин 1 хувиас бага байгаа бөгөөд Зүүн Ази, Номхон далайн бусад зарим орнуудтай харьцуулбал ХДХВ, ДОХ-ын тархалт багатай 5 улс орны тоонд багтдаг хэдий ч ХДХВ-ын бүртгэгдсэн тохиолдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна. ХДХВ-ын 2006 оны эцэс хүртэл нийт 25 тохиолдол бүртгэгдсний 20 нь 2005-2006 онуудад бүртгэгджээ⁹. Өнөөгийн байдлаар ХДХВ-ийн халдвар авсан хүмүүсийн 17 нь эрэгтэй, үүнээс 12 нь ижил хүйстний хоорондох бэлгийн хавьтлаар халдвар авсан байна¹⁰.
39. Манай улсад бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын тархалт нэмэгдэж байгаа нь ХДХВ, ДОХ өвчний халдвар ихсэх нөхцөлийг бүрдүүлж байна. Энэхүү БЗДХ-ын өсөлтийн бараг тал хувийг эрхэлсэн ажилгүй, тэнэмэл, орон гэргүй, төлбөрийн чадвар муутай хүмүүс эзэлж байна¹¹. Статистик мэдээнээс үзвэл 1998 онд нийт халдварт өвчний 35.9 хувь байсан бол 2006 онд 35.3 хувийг БЗДХ эзэлж байна¹².
40. ДОХ-оор өвчилсөн нэг хүний эмчилгээний шууд зардал жилд 3.6-10.2 сая төгрөг байгаа нь Монголын дундаж орлоготой гэр бүлийн жилийн орлогоос 2-6 дахин их байна.
41. Тэргүүлэх бодлогыг хяналтын тогтолцоог бэхжүүлэх, нийт хүн амыг урьдчилан сэргийлэх, түүнчлэн ДОХ-той хүн амын эрхийг хамгаалахад чиглүүлэх шаардлагатай байна.

9 ЭМЯ, ЭМХҮТ-ийн СМА, 2006

10 ДОХ-той тэмцэх Үндэсний сан, Глобаль сан, МЭ консалтинг ХХК, Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүдийн бэлгийн зан үйлийн шуурхай дүн шинжилгээ судалгаа, 2006

11 ЭМЯ, 2006

12 ЭМЯ, ЭМХҮТ, Эрүүл мэндийн үзүүлэлт, 2006

Зорилт 10: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах

Сүрьеэгээр шинээр өвчлөгсдийн түвшин

42. Шинээр сүрьеэ өвчнөөр өвчлөгсдийн тархалтын түвшин 1990 онд 100.000 хүн амд 79 байсан бол 2006 онд 185.3 болж нэмэгдсэн байна. Энэ нь сүрьеэ өвчнийг богино хугацаанд илрүүлэх илрүүлэлт сайжирсантай холбоотой гэж болно. Сүрьеэгээр шинээр өвчлөгчдийн түвшинг аймаг, нийслэлээр 2006 оны байдлаар авч үзвэл Сэлэнгэ, Дорнод, Дархан-Уул, Говьсүмбэр, Хэнтий аймаг, Улаанбаатар хотод улсын дунджаас харьцангуй их байна.
43. Монгол улсад сүрьеэ өвчний илрүүлэлт, эмчилгээний чанар сайжирч нас баралт буурч байгаа боловч өвчлөлийн түвшин нэмэгдэж байгаа нь тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд бэрхшээлтэй болж байна.
44. Сүрьеэ өвчнөөр нас барсан хүний тоо харьцангуй буурч байгаа бөгөөд энэ үзүүлэлт 1990 онд 100 000 хүн тутамд 4.8 байсан бол 2006 онд 2.9 болон буурчээ.

Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдлын хувь

45. Оношлогоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сүрьеэгийн тохиолдол 1994 онд 31.4 хувь байсан бол 2006 онд 82.1 хувь болж нэмэгджээ.
46. Сүрьеэтэй тэмцэх ажлыг хүн амын ядуурлыг бууруулах, орон сууцны болон орчны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах ажилтай нягт уялдуулах, хүн амын ядуу, өвчлөх эрсдэл өндөртэй бүлгүүдийн дотор эрт илрүүлэх, төгс эмчлэх шаардлагатай байна.

Зорилт 11 Хүн амын шүдний өвчлөлтэй тэмцэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх

47. Хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх нь хүний биеийн бүхий л эрхтэнд нөлөөлөх байнгын голомтот халдварыг багасган эрүүлжүүлэх чухал хүчин зүйл гэж үздэг. 2004 онд хийсэн судалгаагаар шүд цоорох өвчний тархалт 5-6 насанд 80.1 хувь, 12 насанд 62 хувь, 18 насанд 72.6 хувь байв. 18 настай бүх хүүхдийн дунд бүрэн шүдтэй хүүхдийн эзлэх хувийн жин 67.5 хувь байна

ЗОРИЛГО 7 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

Зорилт 12: *Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх*

Ойт нутгийн эзлэх хувь

48. Монгол улсын ойт нутгийн хэмжээ 1990 онд 7.8 хувийг эзэлж байсан бол 2015 он гэхэд 9.0 хувь болгож нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэн. Монгол улсын ойт нутгийн эзлэх хувь 1999-2000 онд 8.2-8.5 хувь байснаа 2005 онд 7.8 хувь, 2006 онд 7.7 хувь болж буурсан бөгөөд энэ хурдаар явбал 2015 онд хүрэх зорилтыг хангах боломжгүй болж байна.

Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь

49. Улсын тусгай хамгаалалттай газрын хэмжээ 1990 онд 3.6 хувь байсан бол 2000 онд 13.1 хувь, 2006 онд 13.3 хувь болж хоёроос гурав дахин нэмэгдсэн байна. 2015 онд 30.0 хувь болгох зорилтод хүрэхийн тулд өнөөгийн 13.3 хувийг 2.3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай байна. Харин орон нутгийн хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг нэмж тооцвол дэвшүүлсэн зорилтод хүрэх боломж ойрхон байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн талбайг нэмэгдүүлэхэд бус, хамгаалалтад авсан газар нутгийн менежмент, хяналтыг сайжруулахад анхаарах нь илүү чухал байна.

50. Хүний шууд болон шууд бус үйл ажиллагаа нь байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байна. Ялангуяа олон малтай айл өрхүүд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж байгаа нь хөрс нөхөн төлжих, зарим нутгийн бэлчээрийн ургамлын нөхөн төлжилт зэрэг биологийн төрөл зүйлд ихээхэн хохирол учруулж байна.

Агаарын бохирдолт

51. Улаанбаатар болон бусад том хотуудын агаарын бохирдол жилээс жилд нэмэгдсээр байна. Нийслэлийн эрчим хүч, дулааны эх үүсвэрүүд, тэдгээрийн ашиглалтын байдал гэр хорооллын галлагаа нь агаарын бохирдлын үндсэн шалтгаан болж байна.

52. Химийн хорт бодисын нэр төрөл, тоо хэмжээний худалдаа сүүлийн жилүүдэд эрс өсчээ. 2002 онд нийслэл, 21 аймагт явуулсан химийн хорт бодисын тооллогоор Монгол улсад 563 нэр төрлийн 1.7 мянган тонн химийн бодис байна гэсэн дүн гарчээ. Уул уурхайн салбарын хөгжилтэй уялдан олон төрлийн химийн хорт бодисыг иргэд хууль бусаар, хөдөлмөр хамгааллын ямар ч арга хэмжээ авалгүйгээр хэрэглэж байна.

53. Гэр хорооллын хөгжлийн менежментийг сайжруулах, химийн хорт бодисын болон эрчим хүчний зохистой хэрэглээг бий болгох, хэрэгжилт,

хяналт шинжилгээний мониторингийн үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх замаар агаарын бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Зорилт 13: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах

54. Монгол орны усны нийт нөөц 609.5 шоо.км бөгөөд түүний 500 гаруй шоо. км нь нууруудад, 62.9 шоо. км нь мөстөлтөд байдаг. Ашиглаж болох усны нөөц 34.6 шоо.км байгаагаас 4.96 шоо.км нь гадаргын ус, 0.4 шоо.км нь гүний ус (газрын доорх ус) байна.
55. Монгол улсад гол, горхи, булаг шандны эх хамгаалалтгүйгээс ширгэж бохирдож байна. Гадаргын усны эх үүсвэрийн тооллогын 2003 оны дүнгээр гол, горхи 5565, булаг, шанд 9600, рашаан 374, нуур, тойром 4193 бүртгэгдэж тэдгээрийн 14.9 орчим хувь нь ширгэжээ. Уул уурхай, олборлолтын техник, технологийн үйл ажиллагаанаас 29 гол хэт бохирджээ¹³.

Зорилт 14: 2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын хувийг 2 дахин бууруулах

56. Баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн ам 1990 онд 55 хувийг эзэлж байсан бол 2000 онд 66.2 хувь болон өссөн дүнгээс үзэхэд энэ зорилтыг 2015 он гэхэд хангах боломжтой байна.
57. Монгол Улсын усны хэрэглээний 20 хувь нь гадаргын усны нөөцөөс, үлдсэнийг гүний усны нөөцөөс олборлон, тэдгээрийн 18.1 хувь нь хүнс, ахуйн, 39.3 хувь нь үйлдвэрлэлд, 24 мал аж ахуйд, 17.4 хувь нь ХАА-н усжуулалтанд, 1.2 хувь нь хотын ногоон байгууламжинд хэрэглэдэг байна¹⁴.
58. Монгол орны нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь, нийт сумдын 70 хувь буюу хүн амын 90 гаруй хувь нь фтор багатай, 80 гаруй хувь нь иодын дутагдалтай ундны усыг хоол, ахуйн хэрэглээнд хэрэглэж байна. Сум, суурингийн 30-аад хувь нь эрдэсжилт хатуулаг ихтэй, магний хэмжээ нь эрүүл ахуйн нормоос хэтэрсэн усыг хэрэглэж байна.
59. Засгийн газраас усны бодлогын шинэчлэлийг эрчимжүүлж, гол, мөрний сав газрыг хамгаалах, хэрэглээг зохистой болгох, гадаргын усны ашиглалтыг нэмэгдүүлэх, гүний усны хайгуулын ажлыг өргөжүүлэх, томоохон усан сан байгуулах, бороо, цасны усыг ашиглах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Зорилт 15: 2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц дээшлүүлэх

60. Монгол Улс 2015 он гэхэд эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч буй хүн амыг 50 хувьд хүргэх зорилтыг дэвшүүлсэн хэдий

13 БОЯ, 2007

14 УҮХ, НҮБХС, Усны бодлого төлөвлөлт, 2002, 13 хуудас

ч хэрэгжилт удааширалтай гэж үзэж байна. Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь 1990-2000 онд тогтмол 23 хувийг эзэлж байв.

61. Иймд гэр хорооллыг орон сууцжуулах хөтөлбөрийг эрчимжүүлж, моргейжээр дэмжих хэрэгтэй байна.

ЗОРИЛГО 8 ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Зорилт 16: Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх таатай нөхцөл бүрүүлэх

62. Монгол Улс Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын бүрэн эрхт гишүүн болсон явдал дэлхий нийтийн түншлэлийн хүрээнд гадаад худалдааг өргөжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, аялал жуулчлал хөгжүүлэх зэрэг таатай орчинг бүрдүүлсэн юм. Хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улс жил бүр ихээхэн хэмжээний зээл, тусламжийг хүлээн авч дэд бүтцийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, ядуурлыг бууруулах, хувийн салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, банк, санхүүгийн үйлчилгээг тогтворжуулах зэрэг тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд ашиглаж, бодитой хувь нэмэр болж байна.

Зорилт 17: Далайд гарцгүй Монгол орны хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улс илүү тааламжтай нөхцлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үрашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх

63. Монгол Улс нь дэлхий дээр далайд гарцгүй хөгжиж байгаа 32 орны нэг билээ. Манай улсын экспортын барааны 90 гаруй хувь нь төмөр замаар тээвэрлэгдэж байна. Далайд гарцгүй байдал нь зөвхөн гадаад худалдааны ачаа тээвэрлэхэд бэрхшээл учруулаад зогсохгүй гадаадын хөрөнгө оруулалтад ч ямар нэг байдлаар сөрөг нөлөө үзүүлж байна.
64. НҮБ-ын Далайн эрх зүйн тухай 1982 оны конвенцэд заасан далайд гарцгүй орны хувьд далайд гарах эрхээ баталгаажуулах, илүү хөнгөлөлттэй эрх эдлэх нь манай улсын зорилго юм. Монгол Улс Азийн авто замын үндсэн сүлжээнд холбогдож, түүгээр дамжин далайд гарцтай болоход онцгой үүрэг гүйцэтгэх “Мянганы зам” төслийг 2001 онд баталсан. Цаашид ОХУ, Монгол, Хятадыг холбосон төмөр замын дамжин өнгөрөх хүчин чадлыг нэмэгдүүлэх нь манай улсын хөгжилд онцгой ач холбогдолтой бөгөөд далайд гарцтай болох зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Зорилт 18: Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх

65. Манай улсын гадаад өр 2006 онд ДНБ-ий 31.7 хувьтай (өнөөгийн үнэ цэнээр) тэнцэж байгаа нь Олон улсын валютын сан (ОУВС) болон Дэлхийн банк (ДБ)-ны өрийг тогтворжуулах хамтарсан хөтөлбөрийн хүрээнд тогтоосон босго болох 40 хувиас доогуур байна. Эндээс Монгол Улс нь дунд хугацаанд өрийн дарамтад орох эрсдэл харьцангуй багатай гэж дүгнэж болно.
66. Монгол Улсын Засгийн газар дотоодын болон гадаадын зээллэгийн дунд хугацааны тэргүүлэх чиглэлийг тогтоох зорилгоор Өрийн удирдлагын стратегийг боловсруулж байна. Дунд хугацаанд Засгийн газрын өрийн удирдлагыг сайжруулах, төсвийн болон мөнгөний бодлоготой уялдуулах, санхүүгийн болон хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, эрсдлийг бууруулахаар ажиллаж байна.

Зорилт 19: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах

67. Гадаад орнуудын санхүүгийн дэмжлэг туслалцаатайгаар харилцаа холбооны салбарын технологи шинэчлэгдэж, гадаад ертөнцтэй чөлөөтэй харилцдаг боллоо. 1,000 хүнд ногдох суурин телефон цэгийн тоо 1990 онд 30.8 байсан бол 2006 онд 60.3 болж өсчээ. Түүнчлэн 1,000 хүнд ногдох үүрэн телефон хэрэглэгчдийн тоо 2000 онд 31.2 байсан бол 2006 онд 296.8 болжээ.
68. Монгол Улсын Засгийн газар мэдээллийн технологийн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, айл өрхүүдийг компьютержуулах бодлого баримталсны үр дүнд 2000 онд 1,000 хүн амд ногдох хувийн компьютерийн тоо 12.6 байсан бол 2006 онд 38.4 болж, байнгын интернет хэрэглэгчдийн тоо 2000 онд 2.2 байсан бол 2006 онд 10 болтлоо өсчээ.

ЗОРИЛГО 9 ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ

69. Монгол Улсын Үндсэн хуулинд (1992) Мянганы хөгжлийн 9 дэх зорилгод хамаарах хүний эрхийг хамгаалах асуудлыг олон улсын нийтлэг жишгийн хэмжээнд хуульчилж, ардчилсан засаглалын тулгуур зарчмуудыг улс төр, эрх зүйн хувьд баталгаажуулсан юм. МХЗ-уудын 9

дэх зорилго нь шинээр нэмэгдэж томъёологдсон учраас хэрэгжилтийн явцыг үнэлж дүгнэх талаар нэгдсэн арга зүй, аргачлалын жишиг хараахан тогтоогүй байна.

Зорилт 20: Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахих, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох

70. Монгол Улс НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 40 шахам гэрээнд нэгдэн ороод байна. Монгол Улс гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ирсэн боловч тайлан гаргах, үндэсний хууль, тогтоомжийг олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх талаар хугацаа алдах дутагдал гарч байв. Үүнээс гадна олон улсын гэрээ, конвенцийн талаар иргэдийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй, гэрээ, конвенцийн хүртээмж муу байгаагаас дотоодын хуулийн нэгэн адил хэрэглэх явдал орхигдох тал гарч байна. Тухайлбал, “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай” ХЭҮК-ийн 2006 оны илтгэлд эрүүдэн шүүхийг хориглосон олон улсын гэрээ, конвенцийн заалт үндэсний хууль, тогтоомжид бүрэн хэмжээгээр тусгагдаж чадаагүй ба конвенцийн үзэл санаа, шаардлагууд амьдралд хэрэгжихгүй байгааг 7 тодорхой заалтаар нарийвчлан тодорхойлсон байна.
71. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх зэрэг суурь эрх Үндсэн хуулиар баталгаажсан үндсэн зарчмууд хэрэгжиж байна. Судалгаанд оролцогчдын ихэнх нь хүчирхийллээс айхгүй тайван байж чаддаггүй гэжээ.¹⁵
72. Ардчилал хүний эрхийн шалгуур–мэдээллийн хэрэгслийн эрх чөлөөний үзүүлэлтээр Монгол Улс 2005 онд 54 дүгээрт байсан бол 2006 онд 77 дугаарт буюу хагас эрх чөлөөтэй гэсэн ангилалд оржээ.

Зорилт 21 Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх

73. Монгол Улсад ардчиллын үзэл санаа, зарчмууд төрийн бодлогын хэмжээнд баталгаажин иргэдийн итгэл үнэмшил, үйл ажиллагаа болох чиглэлээр хөгжиж байна. Төрийн эрх мэдэл хуваарилах зарчимд суурилсан ардчиллын үндсэн институтүүдийг ардчилсан сонгуулиар бүрдүүлэн төлөвшүүлж байна. Ардчиллын эдийн засгийн баталгаа болсон хувийн өмч давамгайлсан өмчийн олон хэлбэр бүхий зах зээлийн эдийн засгийн харилцаа төлөвшиж, иргэдийн улс төр, ардчиллын соёл боловсрол аажим боловч дээшилж байна.

¹⁵ Монгол Улсын ХЭҮК, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл, УБ, 2006, 5-11 тал.

Гэвч Дэлхийн банкнаас явуулсан улс орнуудын засаглалын төлөв байдлыг үнэлэх судалгааны дүнгээс үзэхэд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн засаглалын 6 шалгуур үзүүлэлтийн бараг бүх үзүүлэлтээр Монгол Улс сүүлийн жилүүдэд ухарсан байна.

Зорилт 22: Авилгалыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх

74. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний судалгааны дүнгээс (2004) үзвэл судалгаанд оролцогчдын 88.9 хувь нь Монголд авлига дэлгэрсэн гэж хариулжээ. Дэлхийн банкны институтын судалгаагаар Авлигыг хянах үнэлгээ нь 2002 онд -0.08 байснаа 2004 онд -0.52, 2005 онд -0.55 (+2.5-2.5 шкалын үнэлгээгээр) хүртэл буурсан¹⁶.
75. Транспарэнс Интэрнешнл байгууллагаас гаргадаг Авлигын олон нийтийн хандлагын индексээр Монгол Улс 2005 онд 3.0 баллтайгаар 158 улсаас 87 дугаарт авлигад өртсөн улсуудын тоонд багтаж байсан бол 2006 онд 2.8 баллтайгаар 163 улсаас 99 дүгээрт орж 10 гаруй байраар ухарсан байна¹⁷.
76. АНУ-ын ОУХА, Азийн сангаас хамтран 2005 оны 6, 7-р сард Монгол дахь авлигын байдалд хийсэн үнэлгээнд авлигатай тэмцэх асуудлыг бодлогын түвшинд бататгаж, авлигатай тэмцэх бие даасан байгууллага байгуулж ажиллуулах талаар тодорхой зөвлөмжүүдийг гаргажээ¹⁸.

МХЗ-УУДЫН ОРОН НУТАГ ДАХЬ ХЭРЭГЖИЛТ

77. Төвлөрлийг сааруулах үйл явц 1990-ээд оноос хойш тасралтгүй явагдаж байгаа ч удаашралтай, нутгийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллагуудын хоорондын харилцаа болон эрх мэдлийн асуудалд зарим бэрхшээл гарсаар байна. Нутгийн өөрөө удирдах байгууллага болох орон нутгийн Хурлууд нь орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл хязгаарлагдмал, дээрээс хуваарилсан төсвийг ёс төдий баталж байна гэсэн шүүмжлэл гардаг.
78. “Төв, орон нутгийн санхүү, эдийн засгийн хэлтсүүдийн удирдах ажилтнуудын зөвлөгөөн”-ийг 2006 онд зохион байгуулах үеэр орон нутагт тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх асуудлын талаар санал солилцоход нутгийн өөрөө удирдах байгууллагад төсвийн тогтоосон хяналтын тоонд үндэслэн төлөвлөх, батлах эрх олгох, орон нутгийн улсын төсвийн байгууллагуудын зардлыг эдийн засгийн ангилал

16 АЗШҮБТ-ийн судалгааны хүрээнд хийсэн социологийн судалгаа, 2005

17 http://info.worldbank6org/governance/kkz2005/country_report.asp?countryid=147

18 Transparency International. Corruption Perceptions Index, 2006. www.transparency.org

- хооронд шилжүүлэн зарцуулах эрхийг аймгийн Засаг даргад олгох зэрэг асуудлыг санал болгож байв.
79. Улсын төсвийн хөрөнгөөр нийлүүлэх, худалдан авах бүтээгдэхүүний санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсвийн багцад нь багтаан төсвийн байгууллагаар батлах эрх олгох эрх зүйн орчинг бүрдүүлэх зорилгоор “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль”-д, орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, бие даасан байдлыг хангахтай холбогдуулан төсвийн орлогыг оновчтой тогтоох, төсвийн эрхийг өргөтгөх үүднээс “Нэгдсэн төсвийн тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар боловсруулж байна. Эдгээр хуулийн төслүүд батлагдснаар орон нутгийн төсвийн эрх захирагчдын эрх мэдлийг нэмэгдүүлж орон нутгийн төсвийн орлого нэмэгдэн төв, орон нутгийн төсвийн харилцаа сайжирна гэж үзэж байна.
80. Монгол Улсын хууль, УИХ, Засгийн газрын шийдвэрүүд болон бусад эрх зүйн актуудаар баталгаажсан, одоо мөрдөгдөж байгаа нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх бодлогын чанартай олон баримт бичгүүд байгаа боловч тэдгээрийн хоорондын уялдааг хангах талаар эрх зүйн зохицуулалт хангалтгүй, шаардлагатай захиргааны бүтцийг бүрдүүлж чадаагүй байна¹⁹. УИХ, Засгийн газрын баталсан олон төсөл, хөтөлбөрүүдийг хөрөнгийн эх үүсвэргүй шалтгаанаар орон нутагт хэрэгжүүлэх боломж хязгаарлагдмал байна.
81. МХЗ-уудыг орон нутагт хэрэгжүүлэх нь иргэдийг хөгжлийн үйл явцад татан оролцуулах, төрөөс авч хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний үр шимийг тэгш хүртэх боломжийг олгож буй арга замуудын нэг юм. Ийм боломжийг иргэдэд олгохын тулд орон нутаг дахь засаглалыг бэхжүүлэхэд анхаарах шаардлагатай гэж үзээд Монгол Улсын Засгийн газар орон нутгийн засаглалыг бэхжүүлэх, МХЗ-уудыг орон нутагт хүргэх зэрэг төслүүдийг санаачлан НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр дөрвөн аймаг, нийслэлийн хоёр дүүрэгт туршилтын журмаар хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.
82. Ядуурал, тэгш бус байдал нь хэрэглээний ба орлогын ядуурал, боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн үйлчилгээг хүртэх, санал бодлоо илэрхийлэх боломжуудыг хязгаарлахын зэрэгцээ газарзүйн байршил, цаг уур зэрэг олон хүчин зүйлээс шууд хамааралтай асуудал юм. МХЗ-уудын хэрэгжилтийн сайн өнөөгийн байдлаас үзэхэд зорилт бүрийн хэрэгжилт, аймгуудад харилцан адилгүй байгаа нь цаашид санхүү, төсөв, үйл ажиллагааны хүрээг зорилт тус бүрээр нарийн судлан тогтоосон судалгаанд үндэслэн МХЗ-уудыг хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй болохыг харуулж байна.
83. УИХ-аас батлагдсан Монгол Улсын МХЗ-уудын шалгуур 24 үзүүлэлттээс аймгуудаар гардаг 10 шалгуур үзүүлэлт байна. Ядуурал, хоол тэжээлийн

дутал, баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын тоо зэрэг зарим шалгуур үзүүлэлтийн аймгаар гаргасан албан ёсны статистик мэдээлэл байхгүй байна.

84. Иймд эдгээр үзүүлэлтийг аймгийн түвшинд үнэлэх боломжгүй байгаа тул цаашид албан ёсны мэдээллийг орон нутагт бий болгох асуудал чухлаар тавигдаж байна.

МХЗ-УУДЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

85. Монгол Улсын Засгийн газар МХЗ-уудын хэрэгжилтийн явц, байдлыг дүгнэсэн анхны илтгэлээ 2004 онд гаргасан бөгөөд, 2005-2006 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн явц байдлыг дүгнэсэн хоёр дахь илтгэлээ боловсрууллаа.

86. Одоогоор Монгол Улсын МХЗ-уудыг хангахтай холбоотой үйл ажиллагааг нэгтгэн зангидсан нэгж, байгууллага байхгүйгээс салбар бүрт ойлголт ялгаатай, тэдгээрийг салбарын бодлоготой уялдуулж буй байдал, олон нийтийн оролцоог хангаж байгаа байдал янз бүр, мэдээллийн эх үүсвэрүүд зөрүүтэйгээс өгөх дүгнэлт ч ялгаатай гарч байна. ҮСГ-аас ирүүлсэн албан ёсны статистик мэдээллүүд нь эрүүл мэнд, боловсрол, жөндөр, байгаль орчны асуудал эрхэлсэн салбар яамдаас ирүүлсэн мэдээлэлтэй зөрж байв.

87. МХЗ-уудын албан ёсны статистик мэдээллүүд нь МХЗ-уудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд хангалтгүй байгаа учраас холбогдох яамд, төрийн болон төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагууд болон бусад чиглэлээр хийгдсэн судалгаа, шинжилгээний үр дүнг ашиглахад зайлшгүй хүргэж байна. Иймээс Монгол Улсын МХЗ-уудын үндэсний хоёрдугаар илтгэл нь нэмэлт мэдээллүүдээр баяжуулагдсан болно.

88. МХЗ-уудын хэрэгжилтийн тайланг боловсруулахад бодлого боловсруулагчдыг төдийгүй яамдын хяналт-шинжилгээний газар, хэлтсийн ажилтнуудын дүн шинжилгээ хийх чадавхийг сайжруулах шаардлага гарч байна.

89. Монгол Улсын Засгийн газар, НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр “Ядуурал, МХЗ-уудын хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх төсөл” хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд “Ядуурал, МХЗ-уудын хяналт-шинжилгээ, мэдээллийн тогтолцоо”-г бүрдүүлснээр МХЗ-уудын шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулах, шаардлагатай үзүүлэлтийг гаргах чиглэлээр судалгаа хийх, вэбэд суурилсан ДэвИнфо 5.0 программ хангамжийг ашиглан мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийг ашиглах талаар хэрэглэгчдийн чадавхи нэмэгдэнэ.

МХЗ-УУДЫГ ХАНГАХАД ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ҮНЭЛГЭЭ

90. Дэлхийн олон улс орон 2015 он хүртэлх МХЗ-уудаа тодорхойлон хэрэгжүүлж байгаа боловч тэдгээр зорилтуудын хүрээнд авах арга хэмжээнүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрээ тодорхойлон, төсөв, хөрөнгийн нөөцтэй уялдуулсан туршлагатай улс орон цөөн байна. Монгол Улсын Засгийн газар НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр Мянганы тунхаглалын үзэл санаа болон Монгол Улсын Их хурлаас баталсан МХЗ-уудыг хангах шаардлагыг үндэслэн, МХЗ-уудад хүрэх хөгжлийн бодлого, зохицуулалтын үйл ажиллагааны хөрөнгө, санхүүгийн шаардагдах хэрэгцээг тодорхойлсон “Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах хэрэгцээний үнэлгээ”-г 2006 онд боловсруулсан юм.
91. Монгол Улсын Ерөнхий сайдын 2006 оны 28 дугаар захирамжаар “макро эдийн засгийн асуудал, орлогын ядуурал, хоол тэжээл, хүнсний хангамж, боловсрол, жендер, эрүүл мэнд, агаарын бохирдол, усан хангамж, орон сууц, хүний эрх, ардчилал” гэсэн зорилтуудын хүрээнд арван хоёр сэдэвчилсэн ажлын хэсгүүдийг холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулсан. Эдгээр ажлын хэсгүүд нь Сангийн яам, бусад салбарын яамд, НҮБХХ-ийн зөвлөх багтай хамтран НҮБ-ын Мянганы төслийн боловсруулсан “МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээ хийх аргачлал”, Таджикстан улсын “МХЗ-уудыг хангах хэрэгцээний үнэлгээг боловсруулсан” арга зүйг судалсны үндсэн дээр Монгол Улсын МХЗ-уудыг хангахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээний үнэлгээг хийсэн юм.
92. Хэрэгцээний үнэлгээний нэгдсэн дүнгээс үзэхэд, Монгол Улс МХЗ-уудаа хангахад 2007-2015 оны хугацаанд нийт 16,752.8 тэрбум төгрөг буюу 14.0 тэрбум орчим ам.долларын санхүүгийн хэрэгцээ шаардагдаж байна гэсэн тооцоо гарсан байна. Үүний 28 хувь нь дэд бүтэц, 27 хувь нь боловсрол, 19 хувь нь эрүүл мэндийн зорилтуудыг хангахад чиглэгдэх юм. Нийт зардлын 51 хувийг урсгал зардал, 49 хувийг хөрөнгийн зардал эзэлж байна. Хөрөнгө оруулалтыг жил бүрээр нь авч үзвэл 2010 онд хамгийн их хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа нь дэд бүтцийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийг тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөнтэй холбоотой юм. Харин бусад зорилтуудыг хангах зардлын хэмжээ ерөнхийдөө жил бүр жигд өсөлттэй байхаар байв.
93. МХЗ-уудыг хангах үйл ажиллагааг эдийн засгийн тэлэлт, зах зээлийн цаашдын өргөжилттэй уялдуулан хөрөнгө санхүүгийн уян хатан механизмаар дэмжиж чадвал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага байх бөгөөд харин эдийн засгийн цаашдын тогтвортой өндөр өсөлтийг дэмжихэд чиглэгдэхээр байна.

САНХҮҮЖИЛТИЙН СТРАТЕГИ

94. Дээр дурьдсан зардлуудыг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг дотоод болон гадаад эх үүсвэрээр нь тодорхойлохдоо макро түвшний үзүүлэлтүүдтэй уялдуулж, хамгийн оновчтой хувилбарыг тогтоох шаардлагатай байлаа. Эдийн засгийн өсөлтийн өмнөх жилүүдийн хандлага, голлох үзүүлэлтийн харилцан хамаарлыг ашиглан, бизнесийн мөчлөгийн дагуу эдийн засгийн өсөлт, түүний гол үзүүлэлтүүддунд хугацаанд ямар байх төлөв байдлыг харуулж, цаашдаа МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн төсөөллүүдийг санхүүжүүлснээр эдийн засгийн нөхцөл байдал яаж өрнөхийг “Ерөнхийлсөн макро эдийн засгийн загвар”-аар тооцсон юм. Энэ загварыг ашиглан тооцсон “МХЗ_Үндсэн” хувилбараар МХЗ-уудыг хангахад жил бүр 500,0 сая орчим ам.долларын гадаад эх үүсвэрийн хэрэгцээ гарч байна. Харин үлдэж буй хэсгийг нь дотоод эх үүсвэр буюу төсвийн болон хувийн хэвшлийн санхүүгийн эх үүсвэрээр хангахаар байна.
95. “Ерөнхийлсөн макро эдийн засгийн загвар”-ыг ашиглан боловсруулсан бодлогын гурван хувилбараар хийсэн тооцооны нэгдсэн дүнгээс үзэхэд, Монгол Улс МХЗ-уудаа хангах санхүүгийн гадаад, дотоод нөөц боломж байна. Санхүүжилтийн үнэлгээний хувьд, ойрын жилүүдэд огцом их зардал гаргаж санхүүжүүлэх биш, санхүүжилтийг эдийн засгийн өргөжилттэй уялдуулж, эдийн засагт огцом нөлөө үзүүлэлгүйгээр МХЗ-уудыг хангаж, нийт хүн амд ядуучуудын эзлэх хувийг 17 болгон бууруулж болох тооцоо гарсан.
96. Үнэлгээнд МХЗ-ууд, ялангуяа, жендэрийн тэгш байдлыг дэмжих, хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх, хүний эрх, ардчилсан засаглалыг хөгжүүлэх хүрээнд Монгол Улс, тэрчлэн дэлхийн хэмжээнд шийдвэрлэгдээгүй цөөнгүй асуудал байгааг дурьдан, Монгол Улс МХЗ-ууддаа хүрэх бодит нөхцлийг хангах үүднээс “санхүүгийн тусгайлсан стратеги” боловсруулах шаардлагатай гэж дүгнэсэн болно.

СУРГАМЖ

97. МХЗ-уудыг хангах хэрэгцээ нь тус улсын эдийн засгийн өсөлт, хөгжлийн нөөц боломжид дарамт, ачааллыг үзүүлэхээргүй байх бодлогын нөхцөл, төсөөллүүдийг тогтоож, оновчтой сонголт хийх зорилт бас тавьсан. Энэ зорилгоор НҮБХХ-өөс санал болгосон “Ерөнхийлсөн макро эдийн засгийн загвар” (Generalised Macroeconomic Framework—GMF)—ыг ашиглаж, МХЗ-уудыг хангахад шаардагдах хөрөнгийн хэрэгцээг эдийн засгийн өсөлтийн нөөц боломжтой уялдуулж аль болох оновчтой хувилбарыг сонгож хөрөнгө зардлын хэрэгцээг үндэслэл сайтай тооцохыг эрмэлзсэн юм.
98. МХЗ-уудыг хангах хэрэгцээний үнэлгээг боловсруулах явцад Засгийн

газрын байгууллагуудын стратеги төлөвлөлтийн чадавхи, ажилтнуудын арга барил, идэвхи санаачлагыг дээшлүүлэх, яам, салбар хоорондын ажлын уялдаа, мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг сайжруулахтай холбогдсон анхаарах асуудал гарч байв.

99. МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээг хийх явцад тухайн зорилтыг хангахад шаардагдах хөрөнгийг тооцох арга хандлага, аргачлал болон бүтэц нь хоорондоо ялгаатай байв. Ажлын хэсгүүд хүн амын хэтийн тоог ашиглахдаа өөр өөр тоо авснаас тооцоо нь зөрүүтэй гарах, үүний улмаас зорилтын хамрах хүрээг тогтоох, түүнчлэн шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тооцоход бэрхшээл гарч байв. Ажлын хэсгүүдийн гишүүд солигдох, МХЗ-уудын хэрэгцээний үнэлгээний сургалтанд хамрагдаж байгаагүй шинэ хүн ажлын явцад оролцох зэрэг нь ажлын чанар, үргэлжлэх хугацаанд нөлөөлж байлаа. Иймээс ажлын хэсгүүдийн гишүүдийг үнэлгээ хийх аргачлалд сургах, тэдний тодорхойлсон арга хэмжээнүүдийг хооронд нь уялдуулах, давхардлыг арилгах зорилгоор цуврал хэлэлцүүлгүүд хийж байв.
100. МХЗ-уудыг хангахад шаардагдах хэрэгцээний үнэлгээ хийх ажлын хүрээнд НҮБ-ын зөвлөхүүдийн оролцоотойгоор хөгжлийн бодлого, санхүүгийн хэрэгцээний оновчтой хувилбаруудыг сонгон, үр дүнг нь дүгнэн шинжилдэг макро–эдийн засгийн ерөнхий загварыг ашигладаг болов. Ингэснээр стратегийн төлөвлөлтийн чадварыг дээшлүүлэх, мэдээллийн баазыг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой боллоо.



Хавсралт

ЗОРИЛГО/ ЗОРИЛТ/ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Суурь 1990	Явц			Зорилт 2015	Шаар-дагдах жил ¹	Үнэлгээ ²
		2000	2005	2006			
ЗОРИЛГО НЭГ. ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БУУРУУЛАХ							
ЗОРИЛТ 1	Ядуурлын түвшин	36.30 ⁽⁹⁵⁾	35.60 ⁽⁹⁸⁾	36.10 ⁽⁰²⁾	18.00	30	Улаан
ЗОРИЛТ 2	Тураалтай хүүхдийн хувь	12.00 ⁽⁹²⁾	12.70	6.30	0	8	Боломжтой
ЗОРИЛТ 3	Залуучуудад зориулсан таатай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх. Газар ашиглах боломжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх журмыг хөгжүүлэх, ажил эрхлээгүй иргэн бичил эзэл авах боломжийг бий болгох замаар ажилгүй хүмүүс ялангуяа, залуучуудад зориулсан ажлын байр бий болгоно.
ЗОРИЛТ 4	Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холболдон гарч буй сөрөг үзэлдлийг багасгах, шилжигсдийн эрх ашигийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх
ЗОРИЛГО ХОЁР. БҮХ НИЙТЭЭР АНХАН ШАТНЫ БОЛОВСРОЛ ЭЗЭЭМШИХ							
ЗОРИЛТ 5	2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох	95.90 ⁽⁹⁷⁾	95.00	93.30	100.00	17	Ухарсан
	Бага боловсролын хамран сургалтын цэвэр жин	91.00	83.60	101.20	100.00	18	Ухарсан
	Нэгдүгээр ангид элсэн ороод 5 дугаар анги хүртэл суралцагчдын хувь	99.00	97.70	...	100.00	...	Ухарсан
	15-24 насны залуусын бичиг үсэг тайлагдалтын хувь
ЗОРИЛГО ГУРАВ. ХҮЙСИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРЛОЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ							
ЗОРИЛТ 6	2005 онд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд хүйсийн ялгааг арилгах	1.03 ⁽⁹⁵⁾	1.01	0.98	1.00	12	Боломжтой
	Бага боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	1.33 ⁽⁹⁷⁾	1.20	1.11	1.03	...	Эрт хүрсэн
	Ерөнхий боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн харьцаа	...	1.72	1.53	1.53	20	Улаан
	Дээд боловсрол эзэмшиж байгаа эмэгтэй, эрэгтэйчүүдийн тооны харьцаа	51.10	50.40	53.10	50.00	22	Ухарсан
	ХАА-с бусад салбарт цалинтай ажил эрхлэж буй хүн амын дотор эмэгтэйчүүдийн эзлэх %	24.90	11.80	6.6 ⁽⁹⁴⁾	30.00	95	Ухарсан
	Үндэсний парламентад сонгогдсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь	7.70 ⁽⁹²⁾	10.90	13.7 ⁽⁹⁴⁾	35.00 ⁽¹²⁾	30	Боломжтой
	Үндэсний парламентад нэр дэвшсэн эмэгтэйчүүдийн эзлэх хувь
ЗОРИЛГО ДӨРӨВ. ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙГ БУУРУУЛАХ							
ЗОРИЛТ 7	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёрроор бууруулах	88.80	44.50	26.00	29.20	...	Эрт хүрсэн
	Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлт тугамд)	64.40	32.80	20.70	22.00	...	Эрт хүрсэн
	Нялхсын эндэгдлийн түвшин (1,000 амьд төрөлт тугамд)	82.30 ⁽⁹¹⁾	92.40	97.50	96.00	...	Эрт хүрсэн
	Улаан бүрхэн эсрэг вакцинажуулалтад хамрагдсан хүүхдийн хувь
ЗОРИЛГО ТАВ. ЭХЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ							
ЗОРИЛТ 8	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд дөрөвний гурваар бууруулах

ЗОРИЛГО/ ЗОРИЛТ/ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Суурь		Явц		Зорилт 2015	Шаар- дагдах жил ¹	Үнэлгээ ²
	1990	2000	2005	2006			
	121.6	166.30	92.70	67.20	50.00	1	Боломжтой
Эхний өндөрдлийн түвшин (100,000 амьд төрөлт бүрт)	100.0	99.60	99.60	99.70	99.80	1	Боломжтой
Эрүүл мэндийн мөргөжлийн ажилтан эх барьсан төрөлтийн хувь
ЗОРИЛГО ЗУРГАА. БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДЛЫН ВИРУС (ХДХВ), ДОХ, СУРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВЧНИЙГ БУУРУУЛАХ
ЗОРИЛТ 9	2015 он гэхэд ХДХВ, ДОХ өвчний халдварыг хаагаарлах, урьдчилан сэргийлэх
ЗОРИЛТ 10	2015 он гэхэд сурьээ өвчний тархалтыг бууруулах
	79.00	124.80	177.40	185.30	100.00	21	Ухарсан
Сурьээгэр шинээр өвчлөгсдийн түвшин (100,000 хүн тутамд)	4.80	3.20	3.40	2.90	0	24	Боломжтой
Сурьээ өвчнөөс шалтгаалсан нас баралтын түвшин (100,000 хүн тутамд)	31.40 ⁽⁹⁴⁾	80.90	79.00	82.10	100.00	18	Боломжтой
Онцлолцоо, эмчилгээний олон улсын стандартын хүрээнд илрүүлж, эмчилсэн сурьээгийн тохиолдлын хувь
ЗОРИЛТ 11	Хүн амын шударгын өвчлөлтэй тэмцэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх
ЗОРИЛГО ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ
ЗОРИЛТ 12	Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот суурин, ялагчуя Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх	7.80	8.50	7.80	7.70	24	Ухарсан
Ойт нутгийн эзлэх хувь	3.60	13.10	13.30	...	15/30.00	...	Боломжтой
Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутгийн эзлэх хувь	11.52	6.57	5.75 ⁽⁹²⁾	...	4.00	...	Боломжтой
Нэг хүнд ногдох нүүрсхүчлийн давхар эслийн ялгаралт (тонн/хүн)
ЗОРИЛТ 13	Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах
ЗОРИЛТ 14	2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын хувийг 2 дахин бууруулах
ЗОРИЛТ 15	Баталгаат эх үүсвэрээс ус хэрэглэж байгаа хүн амын эзлэх хувь	55.00	66.20	...	70.00	...	Боломжтой
2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах	22.60	23.00	50.00	...	Удаан
Эрүүл ахуйн шаардлага хангахуйц нөхцөлд амьдарч байгаа хүн амын эзлэх хувь
ЗОРИЛГО НАЙМ. ХӨРЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ 16	Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зорилтуудад хүрэх таагүй нөхцөл бүрдүүлэх
ЗОРИЛТ 17	Далайд гарцуй Монгол орны хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улс илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн ур ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх
ЗОРИЛТ 18	Урт хугацаанд даваад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, Үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хиндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх
ЗОРИЛТ 19	Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийтэм" байгуулах
ЗОРИЛГО ЕС. ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАЛЛАЛЫГ ХӨРЖҮҮЛЭХ
ЗОРИЛТ 20	Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох
ЗОРИЛТ 21	Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх
ЗОРИЛТ 22	Авлигыг үл тэвчх уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх

¹ Шөлөөр үзүүлэгчдийн хангааралт, үнэлгээг хийхдээ ЕЛУН-ийн МХЗ-ын Бүсийн тайланд хэрэглэсэн үнэлгээний аргачлалыг ашигласан. 2015 онд хүрээгээр дэвшүүлсэн тухайн зорилтыг 2000, 2006 оны өөрчлөлтийн хурдацаар хангахад хэдэн жил хэрэгтэйг тооцож "Шаардлага жил" баганад тавив.

² 2006-2015 он хүртэлх 9 жилээс шаардлага жил -г хасч, 0-эрт хүрсэн, 9-боломжтой, 9-с-удаан, 2006 онд суурь оноос ухарсан бол хугацаанаас ул хамаарч "ухарсан" гэж үнэлсэн.

Дугаар	Зорилт	Явц						Бодлого			Арга хэмжээ	
		Эрт хүрсэн	Хурх болжмтой	Улаан	Ухарсан	Боломжгүй	Үзүүлэлт байхгүй	Хууль, төрөөс баримтлах бодлогын баримт бичиг	Нэгдэн орсон Олон улсын конвенци, гэрээ	Салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө, стратеги	Үндэсний хөтөлбөр	Төсөл, арга хэмжээний хэрэгжилт
1	Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах			✓				–	–	+	+	+
2	Хоол, тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 онд 2 дахин бууруулах		✓				+	+	+	+	+	+
3	Залуучуудад зориулсан таатай, бүтээмж өндөртэй ажлын байр бий болгох стратеги боловсруулж, хэрэгжүүлэх. Газар ашиглах боломжийг нэмэгдүүлэх, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх журмыг хөнгөвчлөх, ажил эрхлээгүй иргэн бичил зээл авах боломжийг бий болгох замаар ажилгүй хүмүүс ялангуяа залуучуудад зориулсан ажлын байрыг бий болгоно.					✓	–	+	–	+	+	+
4	Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжигсдийн эрх ашгийг хамгаалах, эрх зүйн хамгаалалтыг бий болгох, ажлын байраар хангах, орон сууц, эмнэлэг, боловсрол, соёлын болон нийгмийн бусад үйлчилгээнд хамруулах тогтолцоог бүрдүүлэх					✓	+	–	–	–	–	+
5	2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох				✓		+	+	+	+	+	+
6	Хүйсийн ялгааг 2005 онд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын түвшинд арилгах				✓		–	+	+	–	–	+
7	5 хүртлэх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд гуравны хоёроор бууруулах						+	+	+	+	+	+
8	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 онд дөрөвний гурваар бууруулах		✓				+	+	+	+	+	+
9	2015 он гэхэд Хүний дархлал хомсдлын вирус (ХДХВ), Дархлалын олдмол хомсдол (ДОХ) өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх						+	+	+	+	+	+
10	2015 он гэхэд сурьез өвчний тархалтыг бууруулах			✓			+	+	+	+	+	+
11	Хүн амын шүдний өвчлөлтэй тэмцэх тусгай хөтөлбөр хэрэгжүүлэх					✓	+	+	+	+	+	–

Дугаар	Зорилт	Явц					Бодлого			Арга хэмжээ	
		Эрт хүрсэн	Хүрэх боломжтой	Удаан	Ухарсан	Боломжгүй	Түүвлэлт байхгүй	Хууль, төрөөс баримтлах бодлогын баримт бичиг	Нэгдэн орсон Олон улсын конвенци, гэрээ	Салбарын хөгжлийн мастер төлөвлөө, стратеги	Үндэсний хөтөлбөр
12	Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот сууринд, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх				✓			+	-	+	+
13	Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах					✓	+	-	-	+	+
14	2015 он гэхэд баталгаат ундны ус хэрэглэх боломжгүй хүн амын хувийг 2 дахин бууруулах			✓			+	-	-	+	+
15	2015 он гэхэд орон байрны нөхцөл муу хүмүүсийн аж байдлыг мэдэгдэхүйц сайжруулах			✓			+	-	+	+	+
16	Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар МХЗ-дад хүрэх таатай нөхцөл бүрдүүлэх					✓	+	-	-	-	+
	Гадаад худалдаа						-	-	-	-	+
	Гадаадын хөрөнгө оруулалт						+	+	+	+	-
	Банк санхүүгийн систем						+	+	-	-	+
17	Далайд гарцгүй Монгол орны хэрэгцээ, шаардлагыг харгалзан Монгол Улс илүү тааламжтай нөхцлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн ур ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх					✓	-	-	-	-	+
18	Урт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх					✓	-	-	-	-	-
19	Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах					✓	+	+	+	+	+
20	Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэж, чандлан сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангаж, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох					✓	+	-	-	-	+
21	Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх					✓	-	-	-	-	+
22	Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх					✓	+	-	-	-	+

Тэмдэглэгээний тайлбар: + тухайн зорилгод холбогдох баримт бичиг байгаа
- тухайн зорилгод холбогдох баримт бичиг байхгүй
✓ тухайн зорилтын хүрсэн түвшин

МХЗ-уудын зарим гол шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон үнэлэмж, 2006 (аймгуудыг байр эзлүүлснээр)

Хавсралт 3

	Зорилго 2		Зорилго 3		Зорилго 4		Зорилго 5 Эхийн эндэглэлийн түвшин (10000 амьд төрөлд)	Зорилго 6		Зорилго 7 Ойт нутгийн эзлэх %	Аймаг тус бүрээр хэрэгжилтийн дүн (%)
	Бата боловсролын хамран сургалтын цэвэр жин	1-р ангид эрсэдэг 5-р анги хүртэл суралцагч дын %	Бата боловсрол эзэмшиж байгаа охид, хөвгүүдийн тооны харьцаа	ХАА-с бусад салбар чалинтай ажил эрхлэж байгаа хүн амд эмтгэлийн үйлчилгээний эзлэх %	5 хүртэлх насны хүүхдийн эндэглэл (1000 амьд төрөлд)	Нялхсын эндэглэлийн түвшин (100 амьд төрөлд)		Сүрьеэ өвчний тархалт (10000 хүн тутамд)	Сүрьеэ өвчний нас шалтгаалсан нас хүн тутамд (100000 хүн тутамд)		
1	Архангай	10	18	12	17	7	6	1	10	18	65.0%
2	Баян-Өлгий	21	19	1	6	15	9	19	6	11	55.0%
3	Баянхонгор	11	15	12	4	22	22	13	3	2	62.5%
4	Булган	20	7	12	20	2	3	1	11	17	50.0%
5	Говь-Алтай	12	10	4	12	13	12	20	1	1	72.5%
6	Дорноговь	5	2	22	3	18	19	17	13	8	65.0%
7	Дорнод	7	12	10	16	19	16	21	21	20	42.5%
8	Дундговь	19	4	8	22	3	4	1	4	10	62.5%
9	Завхан	14	9	21	19	11	13	11	2	1	60.0%
10	Өвөрхангай	6	6	8	14	17	18	1	9	7	62.5%
11	Өмнөговь	9	1	16	2	20	21	1	7	11	62.5%
12	Сүхбаатар	3	8	19	21	8	10	18	14	8	57.5%
13	Сэлэнгэ	4	22	4	1	4	2	10	22	11	62.5%

14	Төв	22	21	20	5	1	1	1	1	12	19	22	52.5%
15	Увс	7	20	1	7	16	14	8	8	8	1	13	72.5%
16	Ховд	15	13	1	10	9	8	9	9	5	18	12	62.5%
17	Хөвсгөл	17	11	10	15	21	20	1	1	15	13	9	42.5%
18	Хэнтий	16	14	12	10	6	7	14	14	17	22	19	47.5%
19	Дархан-Уул	2	17	4	12	5	5	12	12	20	16	3	65.0%
20	Улаанбаатар	13	3	4	18	13	15	16	16	18	15	21	57.5%
21	Орхон	18	5	16	7	12	11	15	15	16	6	5	57.5%
22	Говьсүмбэр	1	16	16	9	10	17	22	22	19	21	5	52.5%
Зорилт тус бүрээр хэрэгжилтийн дүн (%)		52.0%	44.0%	50.0%	50.0%	94.0%	92.0%	75.0%	63.0%	60.0%	46.0%		60.6%

Тэмдэглэгээний тайлбар

1	Хүрсэн	100.0>	100.0>	1.0=	50.0=	29.2<	22.0<	50.0<	100.0=<	0.0=	2.0<	99.0>
2	Боломжтой	95.0-99.9	93.0-99.9	1.02<1<0.98	47.0>49.9; 50.1>52.0	29.2>33.0	22.1-26.0	50.1-68.0	100.1- 142.0	0.1-1.9	0.1-1.9	75.0-98.0
3	Удаан	91.4-94.9	86.8-92.9	1.04>1.02; 0.96>0.98	45>47; 52.1>54	33.1-38.1	26.1-32.7	68.1-67.1	142.1- 185.2	2.0-2.9	0.0=	51.0-74.0
4	Боломжгүй	91.4<	86.8<	1.04>; 0.96<	45<; 54.0>	38.2>	32.8>	67.2>	185.3>	3.0>	>0.0	50.0<

